



БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ
АУДИТЫН КОД: БНА-2023/12-3-НА-НА

Баянхонгор хот 2023 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цэням
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 99061861 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Должмаа
Утас: 88110538 цахим хуудас: doljmaab@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



Агуулга

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	4
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	6
НЭГ. ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГА	6
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН ТАЛААР	6
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ	7
НЭГ. ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ	8
ОРОН НУТГИЙН СУУРЬ ОРЛОГО 19,781.5 СЯА ТӨГРӨГИЙГ 3.245.0 СЯА ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛЫГ ХҮРГҮҮЛЖ БАЙНА	8
ХОЁР. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ	11
САНАЛ: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ 790.0 СЯА ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ САНАЛЫГ ХҮРГҮҮЛЖ БАЙНА	11
ГУРАВ. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ	12
ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ 2,480.4 СЯА ТӨГРӨГӨӨР ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛЫГ ОРУУЛЖ БАЙНА	12
ДҮГНЭЛТ	16
АУДИТЫН ЯВЦАД ЦУГЛУУЛСАН НОТЛОХ ЗҮЙЛС БОЛОН АУДИТЫН ДҮНД ҮНДЭСЛЭН ДАРААХ ДҮГНЭЛТ ГАРГАЖ БАЙНА	16
ЗӨВЛӨМЖ	16
ХАВСРАЛТ	17



Товчилсон үгийн тайлбар

ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл”, түүнчлэн аймгийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” заалт, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/04 дугаар тушаал, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2023 оны А/02 дугаар тушаалыг үндэслэн аудит хийв.

Аудитын зорилт

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд дүн шинжилгээ хийж, төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсөвт орох татварын болон татварын бус орлогыг бүрэн төлөвлөсөн эсэх
- Төсвийн зарлагыг арвилан хэмнэлттэй, үр нөлөөтэйгөөр төлөвлөсөн эсэх
- Төсвийн санхүүжилтийн үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх

Аудитыг хамарсан хүрээ

Баянхонгор аймгийн Засаг даргаас Сангийн яаманд өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөл, аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, аймгийн Татварын хэлтэс, ГХБХБГ, ОНӨГ зэрэг бусад шалгагдагч болон хамрагдагч этгээдээс ирүүлсэн холбогдох бусад баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудитын MNS6817:2020 Монгол Улсын стандарт, МҮЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, МҮЕА-ын 2022.08.17-ны өдрийн А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” зэрэг аудитыг чиглүүлж гарсан бусад заавар, аргачлалыг мөрдөн, аудитад шалгагдагч болон хамрагдагч байгууллагын газар нэгжүүдийн холбогдох албан тушаалтнуудаас нэмэлт тодруулга, лавлагаа, судалгааг авч, ярилцлага хийх, аудитын явцад цуглуулсан баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлж нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт өгч байна.



**Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлтүүд:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Сангийн яамны 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Алтантуяа, Б.Должмаа, Б.Азбаяр нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2023 оны 07 дугаар сарын 18-ний өдөр батлуулж, талбарын ажлыг гүйцэтгэж, орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн үр ашгийг сайжруулах, зардал бууруулах дүгнэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн ИТХ-д хүргүүлэв.



ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны орон нутгийн төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь "...аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, ...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх" гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж, дүгнэлт гаргав.

Баянхонгор аймгийн Засаг даргаас 2024 оны орон нутгийн төсвийн төслийн нийт зарлагыг 61,340.9 сая төгрөгөөр, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс 42,717.9 сая төгрөг, орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 18,623.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны жилийн төсвийн зарлагыг 58,203.1 сая, ОНХС-ийн шилжүүлэг 20,660.6 сая, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 38,421.5 сая, орон нутгийн татварын орлого 19,781.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлийн хүрээнд улсын төсөвт төвлөрүүлэх зээлийн эргэн төлөлтийг "Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас 2024 онд улсын төсөвт зээлийн үндсэн төлбөр 260,0 сая, хүүгийн төлбөр 47.6 сая" 307.6 сая төгрөгөөр баталжээ.

НЭГ. ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГА

Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн төслийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 7/1573 дугаар албан бичгээр Төсвийн тухай хуулийн шаардлагын дагуу бэлтгэсэн төсвийн төслийг ирүүлсэн байна. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн "Орон нутгийн 2024 оны төсвийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл"-ийг удирдлага болгосон байна. Үүнд.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган талаар

- "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх захир арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын 1.2-1.4-т заасан чиглэлийг 2024 оны төсөвт баримтлах
- "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Худалдан авах ажиллагааны газар байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу зохион байгуулж, албан хаагчдын орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг Засаг даргын батлагдсан орон тоо төсөвтөө багтаан зохион байгуулах
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль



болон Малын тоо толгойн албан татварын тухай хуульд тус тус нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан иргэд, хуулийн этгээдэд эдгээр хуулийн нэмэлт өөрчлөлтийг сурталчлан таниулах ажлын харвья татварын албатай хамтран зохион байгуулах, татварын орлогыг дайчлах зэргээр орон нутгийн төсвийн орлогын хэмжээг нэмэгдүүлэх

- Орон нутагт иргэд шилжин, тогтвортой суурьших орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор иргэдтийг орон сууцжуулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг тухайн орон нутгийн онцлог, дэд бүтцийн бэлэн байдал, иргэд зорилтот бүлгийн шаардлагатай үйлдүүлэн зохион байгуулах
- Хөдөөд орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийн тодорхой хэсгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх

Хүснэгт 1. Төсвийн тухай хуулийн шаардлага

№	Төсвийн тухай хуулийн заалт	Тусгасан эсэх	Тайлбар
1	33.2.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого	Тийм	
2	33.2.2.төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ	Тийм	
3	33.2.4.бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг	Тийм	
4	33.2.5.төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар	Тийм	
5	33.2.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/	Хангалттай бус	Жил бүр төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

Аймгийн 2024 оны төсвийн бодлого нь “Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах төрийн үйлчилгээг саадгүй хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, улсаас баримталж буй төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилго бүхий төсвийн төслийг боловсруулсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн төсөл нь Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт агуулгаараа нийцэж байгаа боловч орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийх зарим төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтыг зөрчсөн байна.

Баянхонгор аймагт 2024 онд хэрэгжүүлэх “Аймгийн хөгжлийн төлөвлөгөө”-г 55 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 2,058.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна.

Баянхонгор аймагт 2024 онд хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэхээр 2,058.0 сая төгрөгийн 55 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө үр дүн харагдахуйц бус, хэт жижиглэсэн тул Хөгжлийн бодлогод нийцүүлэн дахин төлөвлөх, үр ашгийг нэмэгдүүлэх талаар дахин авч үзэх нь зүйтэй байна.



НЭГ. ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

Орон нутгийн суурь орлого 19,781.5 сая төгрөгийг 3.245.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна.

Санал 1. Цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй хөдөлмөр эрхлэлтийн орлого 11,616.0 сая төгрөгийн татварын орлогыг 1,456.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 13,072.0 сая төгрөгөөр төлөвлөх

Үндэслэл:

Шинэ сэргэлтийн бодлого Хот, хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд

- Орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 2024 оны 4 дүгээр сараас эхлэн суманд ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчид 40 хувийн нэмэгдлийг олгох, төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ.

Нийтлэг үйлчилгээний салбарын ажилчдын цалинг 20 хувь нэмэгдүүлэх бол түүнээс бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэгдүүлэхээр баталсан хуулийн үндэслэлээр цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын суурь зардал 20,767.2 сая төгрөгийг орон нутаг 10,033.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Баянхонгор аймагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд 2024 онд бүтээн байгуулалт хийж, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлж ажлын байр нэмэгдүүлэх талаар олон нийтэд мэдээлсэн байна.

Иймд дээрх нөхцөл байдлаас үзэхэд зөвхөн төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдлээс тооцоход Цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй хөдөлмөр эрхлэлтийн татварын орлогыг 1,456.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.

Санал 2. Ан амьтны нөөц ашигласны орлогыг 587.0 сая төгрөгөөр оруулахаар Сангийн яам хянасныг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,587.0 сая төгрөгөөр төлөвлөх

Үндэслэл: Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод бага хэмжээгээр төлөвлөж, давуулан биелүүлсэн орлогыг сумдын ИТХ-аар тодотгон зарцуулж байгаа нь төсвийн хөрөнгийн үрэлгэн зарцуулах нөхцөл бүрдэж байна.

Орон нутгийн төсвийн орлогод ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 2019 онд 524.8 сая, 2020 онд 176.5 сая төгрөг байгаа нь Ковид цар тахлаас шалтгаалан ан, агнуур хийх боломж бүрдээгүйтэй холбоотой байна.

Харин 2021 онд 1447.0 сая төгрөгийн орлого орсон, 2022 онд 921.7 сая төгрөгөөр төлөвлөсөн ба БОАЖЯамнаас 134 шонхор агнах зөвшөөрөл олгосны дагуу гүйцэтгэлээр 4,556.5 сая төгрөг, 2023 онд 1,012.1 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс гуравдугаар улирлын байдлаар 2,182.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээд байна.



Иймд 2024 оны төсөлд Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна

Санал 3. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг 650.0 сая төгрөгөөр батлуулахаар ирүүлснийг 689.0 сая төгрөг болгон 39.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх

Үндэслэл: 2024 оны орон нутгийн төсвийн орлогын хяналтын хуудсанд ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг 2024 онд 622.0 сая төгрөгөөр тооцон явуулсныг Сангийн яам 650.0 сая төгрөгөөр хянасан байна.

“Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргаа”-аас гаргасан тооцооллоор уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар 8 аж ахуйн нэгжээс 606.3 сая, рашааны нөөц ашигласны төлбөрөөр 3 аж ахуйн нэгжээс 77.1 сая, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах усны төлбөрт “Чандмань Баянхонгор” ХК 6.4 сая төгрөг, нийт 2024 онд 689.8 сая төгрөг орохоор тооцсныг давтан тооцоолол хийхэд үндэслэлтэй байна.

Иймд 2024 оны ус, рашааны ашигласны төлбөрийг 39.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна.

Санал 4. Авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 650.0 сая төгрөгөөр батлуулахаар төсөвт тусгаж ирүүлснийг 900.0 сая төгрөг болгон 250.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх

Үндэслэл: Авто болон өөрөө явагч хэрэгслийн татварыг өмнөх оны гүйцэтгэлийг харгалзан 610.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд үүнийг татварын нэгдсэн системээс авч авто тээврийн хэрэгслийн татварын ногдуулалтыг авч үзэхэд 21777 тээврийн хэрэгсэлд 1088.0 сая төгрөгийн ногдуулалтыг хийсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 03/980 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2023 оны “Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний тухай” А/57/48 дугаар хамтарсан тушаал болон “Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө”-г баталж, 21 аймгийн Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, Засаг даргын Тамгын газруудад хүргүүлсний дагуу Баянхонгор аймгийн хэмжээнд бүртгэлтэй 21777 тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг хөтөлж 6780 автомашиныг бүртгэлээс хасахаар шийдвэрлэсэн байна.

Авто тээврийн тухай хуулийн 171.1-д “Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ” гэж авто тээвэр эзэмшигчийн үүрэг болгон заасан байхад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн татварыг төлөхгүй байх үндэслэл байхгүй байна.

Иймд татварын орлогыг хуульд заасан хэмжээгээр бүрэн авч төвлөрүүлэх шаардлагатай гэж үзэн 2024 оны төсвийг 2023 оны татварын ногдуулалтаас 6780 тээврийн хэрэгслийг хасаж тооцон, өмнөх онуудын бүртгэлтэй автотээврийн



хэрэгслийн дутуу төлөлт 100.0 сая төгрөгийг тооцон нийт 900.0 сая төгрөгөөр төлөвлөхийг санал болгож байна.

Санал 5. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 40.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 140.0 сая төгрөг болгон өөрчлөх

Үндэслэл: Төсвийн төсөлд Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг Сангийн яам 40.0 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн ба аудитын явцад Шинэжинст сумын Баянхөндийн уурхайд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэ Монгол” ХХК-аас 2023 онд тус төрлийн төлбөрийн орлогоор 107.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тус компани нь баяжуулах үйлдвэрийн барилга эхлүүлсэн бөгөөд цаашид тухайн барилга болон үйлдвэрийн дагалдах барилгууд баригдахаар төлөвлөж байгаа талаар тус компанийн Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн тайлбар өгсөн тул 2024 онд өмнөх онд орсон орлого өсөн нэмэгдэхээр байна.

Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсэд буй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж буй 10 км автозамын далангийн шорооны ажилд зориулан 112,521 м.куб түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахаар зураг төсөвт суусан ба 1метр куб буталсан чулууг хуульд заасан хувь хэмжээгээр тооцоход ойролцоогоор 56.0 сая төгрөгийн төлбөрийн орлого орохоор байна.

Иймд Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 140.0 сая төгрөгөөр оруулах боломжтой байна.

Санал 6. Газрын дуудлага худалдааны орлогыг 50.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 250.0 сая төгрөг болгон өөрчлөх

Үндэслэл: Төсвийн төсөлд газрын дуудлага худалдааны орлогыг 50.0 сая төгрөгөөр Сангийн яам хянаж ирүүлсэн ба 2023 онд газрын дуудлага худалдааны орлогоос 315.8 сая төгрөг батлагдсан байна. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 49 нэгж талбарт дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явагдахаар төлөвлөснөөс 5 сумд 25 нэгж талбарт дуудлага худалдаа зарлагдаж 12 нэгж талбар 112.9 сая төгрөгөөр зарагдсан орлого бүрэн төвлөрсөн байна.

Иймд 2023 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан дуудлага худалдаа зарлагдаагүй 24 талбар, дахин дуудлага худалдаа явуулах 13 газрын орлого болон 2024 онд Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийг дагасан үйлдвэр, үйлчилгээний зориулалттай газрын дуудлага худалдааны орлого зэргээс 200.0 сая төгрөг нэмэгдүүлэх санал оруулж байна.

Санал 7. Виртуал студийн менежментээр хувьчлах гэрээг цуцлан дахин дуудлага худалдаанд оруулж орон нутгийн орлогыг цаг хугацаанд нь төвлөрүүлж 200.0 сая төгрөгийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх

Үндэслэл: Баянхонгор аймгийн төвд байгуулсан Виртуал студийг менежментээр хувьчилсан боловч Аймгийн орон нутгийн өмчийн газартай гэрээ байгуулсан аж ахуй



нэгж нь гэрээгээр хүлээсэн 32.8 сая төгрөгийг аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, үйл ажиллагаагүй явуулаагүй байна.

Иймд Виртуал студийн менежментээр хувьчилсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, орон нутгийн өмчийг үнэгүйдэхээс сэргийлж 225.0 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

Мөн Шинэ суурьшлийн бүсэд баригдаж 2023-2024 онд ашиглалтад орох ингэний сүүний үйлдвэр, мах ногооны зоорь, өвлийн хүлэмжийн үйл ажиллагаа, менежментийг төр хувийн хэвшлийн түншлэлээр менежментийн хувьчлал хийж орон нутгийн өмчийн орлогыг нэмэгдүүлэх боломж байна.

ХОЁР. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ

Санал: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 төсвийн зарлагыг 790.0 сая төгрөгөөр бууруулах саналыг хүргүүлж байна.

Үндэслэл: Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнээс 790.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хасаж төсвийн зарлагыг 790.0 сая төгрөгөөр бууруулах. Үүнд:

- Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 16 дугаар ангид “Өндөр барилгад гарсан гал түймэр, аваар ослын үед ашиглах автомеханик шатны тусгай зориулалтын автомашин”-ыг шийдвэрлэх арга хэмжээнд 100.0 сая төгрөг төлөвлөсөн нь авахаар төлөвлөсөн тусгай зориулалтын автомашины зах зээлийн үнэ 1,600.0 сая төгрөг байхад үлдэгдэл хөрөнгийг хаанаас шийдвэрлэх нь тодорхой бус байна.
- Заган ойг хашин хамгаалах зардалд 180.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснийг байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэх боломжтой.
- Үзэсгэлэн худалдаанд шаардлагатай зориулалтын тоног төхөөрөмжийг худалдан авах, Үзэсгэлэн худалдааг 2-оос доошгүй удаа зохион байгуулах арга хэмжээнд 60.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа багийн спортын заалнууд, “Ажилсаг төв”, хуучин Биеийн тамирын спортын ордон зэрэг газруудад жилд 2 удаа үзэсгэлэн худалдаа явуулах боломжтой байхад 5х5 хэмжээтэй нэг бүр нь 3.5 сая төгрөгийн өртөгтэй майхан худалдан авах нь төсвийн үр ашиггүй зарлага болохоор байна.
- Баянхонгор аймгийн ЗДТГ-аас авсан судалгаагаар 2022 онд 121.1 сая төгрөгийн Ланд-76 автомашиныг 2 ширхгийг худалдан авч, 2022.12.31-ний өдөр орлогод авсан Ланд-76 автомашиныг Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023.11.13-ны өдрийн 108 дугаар захирамжаар Жинст сумын ЗДТГ-т шилжүүлсэн байна.

Иймд ашиглалтын хугацаа болоогүй байхад хөрөнгийг өөр байгууллагад шилжүүлсэн атлаа 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд 300.0 сая төгрөгөөр аймгийн ЗДТГ-ын ажлын хэрэгцээнд шаардлагатай автомашиныг авахаар төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.



- Төлөөлөгчдийн нэг өдөр үйл ажиллагааны зардалд 150.0 сая төгрөг төлөвлөснийг Баянхонгор аймгийн ИТХ-ын ажлын албаны 2024 оны төсөвт тусгах боломжтой

ГУРАВ. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ

Төсвийн хөрөнгийн үр ашгийг 2,480.4 сая төгрөгөөр дээшлүүлэх саналыг оруулж байна.

Санал 1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөлд иргэдийн санал аваагүй 1,904.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1,305.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байгаа тул иргэдийн санал авсан төсөл арга хэмжээг тусгаж төсвийн үр ашгийг дээшлүүлэх

Үндэслэл: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн жагсаалтыг Баянхонгор сум болон бусад сумдаас ирүүлсэн иргэдийн санал авч эрэмбэлсэн жагсаалтыг авч үзэхэд төсвийн төсөлд иргэдийн санал аваагүй 1,305.0 сая төгрөгийн доорх 6 төсөл арга хэмжээг тусгасан байна.

Хүснэгт 2. Иргэдийн санал аваагүй тусгасан төсөл, арга хэмжээний судалгаа /сая.төг/

№	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ	ЭХЛЭХ ОН	ДУУСАХ ОН	ТӨСӨВТ ӨРТӨГ	ТУХАЙН ОНД БАТЛАГДСАН	Иргэдийн санал
2.4	Шаардлагатай зураг төсөв хийлгэх	2024	2024	600.0	600.0	Иргэдийн санал аваагүй
2.7	Төрийн албан хаагчдыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2024	2024	250.0	250.0	Иргэдийн санал аваагүй
2.10	Баянхонгор сумын "Эрдэнэмандал" хайрхны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	2024	2025	195.0	175.0	Иргэдийн санал аваагүй
2.13	Жинст, Бууцагаан сумдын Засаг даргын тамгын газрыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2024	2024	110.0	110.0	Иргэдийн санал аваагүй
2.15	Жинст сумын сургуулийн дээврийн засварын ажил	2024	2024	70.0	70.0	Иргэдийн санал аваагүй
2.18	Эрдэнэцогт сумын Өвгөнжаргалант багийн төв бүхий спорт заал	2024	2024	679.4	100.0	Иргэдийн санал аваагүй
				1,904.4	1,305.0	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөл

Санал 2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 380.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээний тооцоолол судалгаа, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл байхгүй тул төсөвлөлтийн шаардлага хангасан үр ашигтай төсөл арга хэмжээнд төлөвлөх

Үндэслэл: Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс ирүүлсэн материалд дараах төсөл арга хэмжээнүүдийн зураг төсөл болон урьдчилан тооцоолол байхгүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй 380.0 сая төгрөгийн дараах 3 ТАХ багтсан байгаа нь Төсвийн



тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5² дах заалтыг зөрчиж байна.

Хүснэгт 3. Зураг төсөл болон урьдчилан тооцоолол байхгүй төсөл, арга хэмжээний судалгаа /сая.төг/

№	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ	ЭХЛЭХ ОН	ДУУСАХ ОН	ТӨСӨВТ ӨРТӨГ	ТУХАЙН ОНД БАТЛАГДСАН	Иргэдийн санал
2.6	Баянхонгор сумын нийтийн орон сууцуудын ус хангамжийг сайжруулах	2024	2024	300.0	300.0	Шаардлага хангасан /655 хүний санал/
2.16	Хүрээмарал суманд "Энергийн төв"-ийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, тохижилтын ажлыг хийх	2024	2024	60.0	60.0	Шаардлага хангасан /40 хүний санал/
2.17	Шаргалжуут багийн өрхийн эрүүл мэндийн төвийн гүний худгийг шинээр гаргах	2024	2024	20.0	20.0	Шаардлага хангасан /64 хүний санал/
Дүн				380.0	380.0	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөл

Иймд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5⁴ дах заалтад нийцүүлэн үр ашигтай төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийг санал болгож байна.

Санал 3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх жагсаалтад туссан Наадмын зардлыг 130.0 сая төгрөгөөр бууруулан шаардлагатай хөрөнгөд зарцуулахаар баталж үр ашгийг сайжруулах.

Үндэслэл: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх жагсаалтад туссан наадмын зардлыг 150.0 сая төгрөгөөр төсөвлөж ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60.3.3⁵, Засгийн газрын 2010 оны 271 тогтоолын 1 дэх хэсэг⁶ хэсэгтэй нийцэхгүй байна.

Иймд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад наадмын зардлыг баталсан хэмжээгээр тусгаж Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 271 тогтоолтой нийцүүлэн үр ашигтай төлөвлөж, 130.0 сая төгрөгийн төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийг санал болгож байна.

Санал 4. Орон нутгийн төсвөөс 2024 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад 455.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 380.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 11 төсөл, арга хэмжээний тооцоолол

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

² Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөө, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁴ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөө, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

⁵ 60.3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;

⁶ Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.



судалгаа, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл байхгүй тул төсөвлөлтийн шаардлага хангасан үр ашигтай төсөл арга хэмжээнд төлөвлөх

Үндэслэл: Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс ирүүлсэн Орон нутгийн төсвөөс 2024 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад 455.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 380.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй дараах 11 ТАХ төсөл, арга хэмжээ нь зураг төсөл болон урьдчилан тооцоолол байхгүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй тусгасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁷, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5⁸ дах заалтыг зөрчиж байна.

Хүснэгт 4. Орон нутгийн төсвөөс 2024 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад ТЭЗҮ болон урьдчилан тооцооло байхгүй ТАХ /сая.төг/

№	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ	ЭХЛЭХ ОН	ДУУСАХ ОН	ТӨСӨВТ ӨРТӨГ	ТУХАЙН ОНД БАТЛАГДСАН	Зураг төсөв
	ШИНЭЭР ЭХЛЭХ ТӨСӨЛ ӨРГӨ ХЭМЖЭЭ					
2.7	Жаргалант сумын хуучин сургуулийн цонх солих	2024	2025	225.0	150.0	ТЭЗҮ байхгүй
2.13	Баянхонгор аймгийн Гэгээн шавь 6 дугаар багийн 30 айлын засварын ажил	2024	2024	51.0	51.0	ТЭЗҮ байхгүй
2.14	Зэвсэгт хүчний 339-р ангийн халуун усны барилгын их засварын ажил	2024	2024	38.3	38.3	ТЭЗҮ байхгүй
2.15	Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн гадна бохир усны шугам сүлжээний ажил	2024	2024	25.0	25.0	ТЭЗҮ байхгүй
2.16	Баянбулаг сумын багийн хөгжлийн төвийн засварын ажил	2024	2024	20.0	20.0	ТЭЗҮ байхгүй
2.17	Баянхонгор аймгийн төрийн архивын аюулгүй байдлыг хангах галын хийн системийн цэнэглэлт үйлчилгээ	2024	2024	20.0	20.0	ТЭЗҮ байхгүй
2.18	Жаргалант, Баянговь сумын Онцгой байдлын газрын засварын ажил	2024	2024	20.0	20.0	ТЭЗҮ байхгүй
2.19	"Шинэ бүргэд" боксын сургалтын заалны засварын ажил	2024	2024	19.0	19.0	ТЭЗҮ байхгүй
2.20	Эрдэнэцогт сумын цагдаагийн барилгын засварын ажил	2024	2024	15.0	15.0	ТЭЗҮ байхгүй
2.21	Гурванбулаг суманд байрлах сум дундын цагдаагийн барилгын засварын ажил	2024	2024	12.0	12.0	ТЭЗҮ байхгүй
2.23	Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбарын байрны засварын ажил	2024	2024	10.0	10.0	ТЭЗҮ байхгүй
				455.2	380.2	

Эх сурвалж: Орон нутгийн төсвөөс 2024 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад

⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁸ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.



Иймд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5¹⁰ дах заалтад нийцүүлэн үр ашигтай төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийг санал болгож байна.

Санал 5. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад 380.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 285.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг өөрчлөн үр ашгийг сайжруулах.

Үндэслэл: Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн дотор засварын ажлыг 180.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 85.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй ажлыг төлөвлөсөн байна.

- Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн үйл ажиллагааны хувьд бие даасан, өөрийн үйл ажиллагааны орлогоос засварын ажлыг хэрэгжүүлэх боломжтой тул орон нутгийн төсвийн төсвөөс санхүүжихээр тусгасан 85.2 сая төгрөгийг өөр шаардлагатай ажилд шилжүүлэн төлөвлөх.

- Багийн спорт заалыг засварлаж бүжгийн заал болгох засварын ажлыг 200.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан нь анх иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн бий болсон спорт заалыг тухайн багийн иргэдээс санал авалгүйгээр зориулалтыг өөрчилж байгаа нь нийтийн эрх ашгийг хохироож болзошгүй тул өөр нэн шаардлагатай төсөл, арга хэмжээг төлөвлөх.

⁹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹⁰ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөө, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

1. Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн суурь орлогыг 3,245.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, суурь зарлагыг 790.0 сая төгрөгөөр бууруулах, төсвийн үр ашгийг 2,480.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, нийт 6,515.4 сая төгрөгийн санал, дүгнэлтийг хүргүүлж байна.
2. Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн төсөл нь Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт агуулгаараа нийцэж байгаа боловч орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийх зарим төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтыг зөрчсөн байна.
3. Аймгийн Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээг хэт жижиглэж үр дүн харагдахуйц бус төлөвлөсөн байна.
4. Аймгийн ОНХС-аас хэрэгжих төсөл арга хэмжээнд иргэдээс санал аваагүй болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцэхгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Нэг. Баянхонгор аймгийн ИТХ-д толилуулах нь:

- Шинэ суурьшлийн бүсэд баригдаж 2023-2024 онд ашиглалтад орох ингэний сүүний үйлдвэр, мах ногооны зоорь, өвлийн хүлэмжийн үйл ажиллагаа, менежментийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр менежментийн хувьчлал хийснээр хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Хоёр. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Мөнхсайхан танаа

- Төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д тус тус заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгаж байх.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй, өртөг нэмэгдэх нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх
- Аймгийн Хөгжлийн жилийн төлөвлөгөөг бодитой үр дүн гарах арга хэмжээнд зорилтод түвшинтэй уялдуулж, төсвийн үр ашиг гарахаар төлөвлөх.
- Аймгийн ОНХС-аас хэрэгжих төсөл арга хэмжээнд иргэдээс санал аваагүй болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцэхгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөхгүй байх.



ХАВСРАЛТ

Хавсралт 01 - ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

Хавсралт 02 - ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ

Хавсралт 03 - ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ

1.

ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

Хавсралт №01

/сая төгрөг/

№	Татварын болон татварын бус орлого	Мөнгөн дүн
1	Цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй хөдөлмөр эрхлэлтийн орлогыг нэмэгдүүлэх	1,456.0
2	Ан амьтны нөөц ашигласны орлогыг нэмэгдүүлэх	1,000.0
3	Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх	39.0
4	Авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг нэмэгдүүлэх	250.0
5	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх	100.0
6	Газрын дуудлага худалдааны орлогыг нэмэгдүүлэх	200.0
7	Виртуал студийг менежментийн хувьчлалыг дахин хянаж зохион байгуулах	200.0
	Орон нутгийн орлого нэмэгдүүлэх нийт дүн	3,245.0

ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ

/сая төгрөг/

№	Зардлын төрөл	Мөнгөн дүн
1	Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 16-р ангид өндөр барилгад гарсан гал түймэр, аваар ослын үед ашиглах автомеханик шатны тусгай зориулалтын автомашиныг шийдвэрлэх арга хэмжээнд 100.0 сая төгрөг төлөвлөсөн нь авахаар төлөвлөсөн тусгай зориулалтын автомашины үнийн 6.0 хувийг эзэлж, бусад 94.0 хувийн санхүүжилтийг хаанаас шийдвэрлэх нь тодорхой бус байна.	100.0
2	Заган ойг хашин хамгаалах зардалд 180.0 сая төгрөгийг зарцуулсныг байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахаар төлөвлөх	180.0
3	Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа багийн спортын заалнууд, "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК, хуучин Биеийн тамирын спортын ордон зэрэг газруудад жилд 2 удаа явуулах үзэсгэлэн худалдаа явуулах боломжтой байхад 5х5 хэмжээнтэй нэг бүр нь 3.5 сая төгрөгийн өртөгтэй майхан худалдан авахад 60.0 сая төгрөг төлөвлөсөн байна.	60.0
4	Ашиглалтын хугацаа болоогүй байхад 2022 онд худалдан авсан 121.1 сая төгрөгийн өртөг бүхий суудлын автомашиныг өөр байгууллагад шилжүүлсэн атлаа 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд 300.0 сая төгрөгөөр аймгийн ЗДТГ-ын ажлын хэрэгцээнд шаардлагатай автомашиныг авахаар төлөвлөсөн байна.	300.0
5	Төлөөлөгчдийн нэг өдөр үйл ажиллагааны зардалд 150.0 сая төгрөг төлөвлөсөн	150.0
Төсвийн зарлагыг бууруулах дүн		790.0

ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ

/сая төгрөг/

№	Утга	Мөнгөн дүн
1	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1,904.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээний 1,305.0 сая төгрөгийг иргэдийн санал аваагүй баталсан байх тул иргэдийн санал авсан төсөл арга хэмжээнд баталж төсвийн үр ашгийг дээшлүүлэх	1,305.0
2	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 380.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээний эдийн засгийн тооцоолол судалгааг хийх, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг хийж төсөл арга хэмжээг үр ашигтай хэрэгжүүлэх.	380.0
3	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Наадмын зардлыг 130.0 сая төгрөгөөр бууруулан шаардлагатай хөрөнгөд зарцуулахаар баталж үр ашгийг сайжруулах.	130.0
4	Орон нутгийн төсвөөс 2024 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад 455.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 380.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 11 төсөл, арга хэмжээний эдийн засгийн тооцоолол судалгааг хийх, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг хийж төсөл арга хэмжээг үр ашигтай хэрэгжүүлэх.	380.2
5	Орон нутгийн төсвөөс 2024 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад 380.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 285.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг өөрчлөн баталж үр ашгийг сайжруулах.	285.2
	Нийт дүн	2,480.4